



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2018 оны 9 сарын 05 өдөр

Дугаар 382

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас  
балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Онцгой байдлын ерөнхий газрын харьяа салбар, нэгжийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 239,881,490.00 (хоёр зуун гучин есөн сая найман зуун наян нэгэн мянга дөрвөн зуун ерэн) төгрөгийн балансын үнэ, 54,972,841.44 (тавин дөрвөн сая есөн зуун далан хоёр мянга найман зуун дөчин нэгэн төгрөг дөчин дөрвөн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг Хил хамгаалах ерөнхий газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Онцгой байдлын ерөнхий газрын дарга, хошууч генерал Т.Бадрал, Хил хамгаалах ерөнхий газрын дарга Ц.Сэргэлэн нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА


ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2018 оны 9 дүгээр сарын 07-ний өдрийн  
386... дугаар тогтоолын хавсралт



**ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА САЛБАР, НЭГЖЭЭС ХИЛ ХАМГААЛАХ ЕРӨНХИЙ ГАЗАРТ  
БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглал- тад орсон огноо	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Үндсэн хөрөнгө шилжүүлж буй байгууллагын нэр	Үндсэн хөрөнгө хүлээн авч буй байгууллагын нэр
1	Foton Iovol FT-1254 жижиг	2017.09.06	119 940 745,00	119 940 745,00	21 655 967,84	98 284 777,16	Давтан сургалт, сэргээн заслын төв	Хил хамгаалах ерөнхий газар
2	Foton Iovol FT-1254 жижиг	2017.02.06	119 940 745,00	119 940 745,00	33 316 873,60	86 623 871,40	Дундговь аймгийн Онцгой байдлын газар	Хил хамгаалах ерөнхий газар
<b>НИЙТ ДҮН</b>			<b>239 881 490,00</b>	<b>239 881 490,00</b>	<b>54 972 841,44</b>	<b>184 908 648,56</b>		
			(хоёр зуун гучин есөн сая найман зуун наян нэгэн мянга дөрвөн зуун ерэн төгрөг)	(хоёр зуун гучин есөн сая найман зуун наян нэгэн мянга дөрвөн зуун ерэн төгрөг)	(тавин дөрвөн сая есөн зуун далан хоёр мянга найман зуун дөчин нэгэн төгрөг дөчин дөрвөн мөнгө)	(нэг зуун наян дөрвөн сая есөн зуун найман мянга зургаан зуун дөчин найм төгрөг тавин зургаан мөнгө)		